

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**

**ТОГТООЛ**

2022 он 8 сар 30 өдөр

Дугаар: 22/02/04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ  
НЭМЭГДҮҮЛЭХ, НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 31, 42 дугаар зүйлүүд, 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг арван тэрбум хүртэл төгрөгөөр нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр арван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ХАЛИУНАА



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2022 он 8 сар 30 өдөр

Дугаар: 22/01/05

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор арван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн үйл ажиллагааны чиглэлд Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
5. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2022 он 8-р сар 30 өдөр


Дугаар: 22/01/06

Улаанбаатар хот

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ**  
**ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор арван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Г.ХАЛИУНАА



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 он 8 сар 30 өдөр

Дугаар: 22/01/05

Улаанбаатар хот

**ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 53, 54-р зүйлүүд, 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2022 оны 8-р сарын 30 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эерэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.
2. Нэмж хувьцаа гаргах, зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
3. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53-р зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2022 он 8 сар 30 өдөр

Дугаар: 22/02/08

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
  1. ТЭМҮҮЛИН Энхмөнх
  2. САРАНЧИМЭГ Энхээ
  3. МАШБАТ Дашзэгвэ
  4. СЛИДАБРОР Рустамходжаев
  5. ХАЛИУНАА Ганчимэг
  6. САЙНБОЛОР Мягмар
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.
  1. БЭХБАТ Содном
  2. БАЙЛИХҮҮ Дамбачүлтэм
  3. НОМИНГЭРЭЛ Лхагвасүрэн
3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ХАЛИУНАА



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2022 он 8 сар 30-дөр

Дугаар: 22/02/09

Улаанбаатар хот

**ОХИН КОМПАНИ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 6.3, 62.2.9-р зүйлүүд, 2022 оны 8-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх зорилгоор мэдээлэлийн технологи, маркетинг зэрэг салбарт үйл ажиллагаа явуулах “Евразиа дижитал венчере” ХХК болон “Евразиа секьюритис” ХХК гэх охин компаниудыг үүсгэн байгуулеугай.
2. Дээр заасан оноосон нэр бүхий охин компаниудын 100 хувийн хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчаар “Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК-г бүртгүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бусад гэх асуудлын хүрээнд шийдвэрлэсэн болохыг дурдсугай.
4. Шинээр байгуулж буй охин компаниудын дүрэм журамыг боловруулж улсын бүртгэлийн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг ТҮЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА

